БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код: БНА-2021/134/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БСШУЯ | Боловсрол, соёл шинжлэх ухааны яам |
| БСУГ | Боловсрл, соёл урлагийн газар |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 13
3.Аудитын тайлан ..... 13
3.1. Ерөнхий зүйл ..... 13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт..... 14
3.4. Материаллаг байдал ..... 15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... 16
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
3.9. Аудитын илрүүлэлт ..... 18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 19
Аудитын зөвлөмж ..... 20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд..... 20
4. Менежментийн захидал..... 20
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... 22

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/78

танай __________ -ны №__________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.УУГАНБАЯР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба төсвийн захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас 80.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Аудитын гол асуудал

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Байгууллагын даргын 2020.12.15-ний өдрийн А/24 дугээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс байгуулахдаа бүрэлдэхүүнд нь нярвыг оруулсан, санхүүгийн тайланд үлдэгдлээр байгаа бараа материалаас 15670.0 мянга, үндсэн хөрөнгөөс 60967.8 мянга, нийт 76637.8 мянган төгрөгийн бүтгэлтэй хөрөнгийг тооллогын комисс тоолоогүй, нягтлан бодогч тооцоо акт үйлдээгүй;
- Байгууллагын нярав, нягтлан бодогч нар хөрөнгийг авсан тухай бүрд орлогод авдаггүй, авсан хугацаанаас хойш төлбөрийг шилжүүлэхдээ нярвын тайланг гаргаж, санхүүгийн программд бүртгэн нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөөгүй, нярав бараа материалын тайланг гаргахдаа эхний үлдэгдлийг материал тус бүрээр гаргалгүй бөөн дүнгээр гаргасан байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг", 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 12 дугаар зүйлийн 12.2 дахь "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг ....жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ", 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.6 дахь "Ерөнхий нягтлан бодогч нь .....эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Оршин байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,309,045.20** | **48,453,034.20** |
| **33** | **АВЛАГА** | 1,789,353.00 | 9,894,242.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 168,993.00 | 9,242.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,620,360.00 | 9,885,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,620,360.00 | 9,885,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31,519,692.20 | 38,558,792.20 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,000,000.00 | 3,610,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 35130 | Эм боох материал | - | 610,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,519,692.20 | 34,948,792.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 164,500.00 | 736,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,558,036.00 | 8,679,536.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 237,100.00 | 237,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,560,056.20 | 25,296,056.20 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **723,468,819.32** | **785,585,756.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 723,468,819.32 | 785,585,756.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 703,944,819.32 | 766,061,756.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 745,025,682.00 | 858,547,377.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (157,129,324.56) | (184,573,974.04) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 164,104,717.91 | 166,176,879.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (135,214,122.23) | (145,829,357.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 89,440,829.80 | 88,577,079.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (40,956,949.09) | (52,976,374.77) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 46,741,537.12 | 46,741,537.12 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (21,398,845.23) | (25,572,998.49) |
| 39217 | Ном | 13,331,293.60 | 14,971,587.60 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,524,000.00 | 19,524,000.00 |
| 39301 | Програм хангамж | 622,600.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (622,600.00) | (200,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,524,000.00 | 19,524,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **756,777,864.52** | **834,038,791.14** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **756,777,864.52** | **834,038,791.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 756,777,864.52 | 834,038,791.14 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 290,170,245.35 | 290,170,245.35 |
| 51101 | Өмч: - төрийн | 290,170,245.35 | 290,170,245.35 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (92,491,478.05) | (15,230,551.43) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (92,491,478.05) | (92,491,478.05) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 77,260,926.62 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 559,099,097.22 | 559,099,097.22 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **756,777,864.52** | **834,038,791.14** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **564,205,309.80** | **760,230,187.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,256,409.80** | **123,686,107.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,256,409.80 | 123,686,107.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,256,409.80 | 123,686,107.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 300,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,256,409.80 | 123,386,107.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **554,948,900.00** | **636,544,080.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 509,175,400.00 | 523,914,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 509,175,400.00 | 523,914,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 683,000.00 | 27,780,500.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 683,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 14,377,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 13,403,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45,090,500.00 | 84,773,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,090,500.00 | 84,773,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 76,080.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 76,080.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **548,338,315.45** | **673,249,260.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **548,338,315.45** | **673,249,260.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 534,194,154.45 | 593,710,999.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 339,671,843.00 | 385,358,538.00 |
| 210101 | Үндсэн цалин | 326,639,469.00 | 379,356,187.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 1,708,636.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,032,374.00 | 4,293,715.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,909,047.00 | 49,304,583.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,360,646.00 | 34,047,561.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,455,994.00 | 3,840,359.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,736,633.00 | 3,072,285.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 668,706.00 | 741,712.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,687,068.00 | 7,602,666.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,500,733.00 | 70,584,922.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,288,673.00 | 2,892,682.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,212,060.00 | 67,692,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,666,266.50 | 7,164,333.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,703,350.00 | 590,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,392,050.00 | 3,633,710.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,081,346.00 | 1,606,973.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 627,300.00 | 55,950.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,051,500.00 | 636,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 874,270.00 | 438,500.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 203,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,936,450.50 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,975,640.00 | 13,523,860.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 384,900.00 | 853,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,290,740.00 | 11,114,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 1,556,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,808,715.00 | 5,460,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,808,715.00 | 5,460,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,696,200.00 | 808,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,696,200.00 | 808,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 683,000.00 | 1,960,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 683,000.00 | 1,510,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 59,282,709.95 | 59,546,463.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,004,000.00 | 1,958,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 937,500.00 | 555,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 55,341,209.95 | 57,033,463.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,144,161.00 | 79,538,261.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,312,600.00 | 21,757,680.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 76,080.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 837,000.00 | 8,561,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,475,600.00 | 7,304,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 5,815,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,831,561.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,831,561.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 11,319,678.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 11,319,678.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 46,460,903.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 33,960,903.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **15,866,994.35** | **86,980,926.62** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 108,796.75 | 9,720,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 108,796.75 | 9,720,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -108,796.75 | -9,720,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **15,758,197.60** | **77,260,926.62** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **554,948,900.00** | **636,844,080.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **300,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 300,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 300,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 300,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **554,948,900.00** | **636,544,080.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 509,175,400.00 | 523,914,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 509,175,400.00 | 523,914,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 683,000.00 | 27,780,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 14,377,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 13,403,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45,090,500.00 | 84,773,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,090,500.00 | 84,773,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 76,080.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 76,080.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **498,270,544.00** | **631,359,786.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **498,270,544.00** | **631,359,786.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **483,801,986.00** | **551,769,925.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 341,941,300.00 | 386,720,818.00 |
| 210101 | Үндсэн цалин | 273,101,000.00 | 302,263,474.97 |
| 210102 | Нэмэгдэл | 20,790,900.00 | 38,287,984.81 |
| 210104 | Урамшуулал | 30,634,400.00 | 46,169,358.22 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,415,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,742,700.00 | 47,824,552.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,273,618.00 | 33,362,098.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,361,723.00 | 3,083,707.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,692,100.00 | 2,995,403.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 676,200.00 | 769,544.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,739,059.00 | 7,613,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,198,733.00 | 70,584,922.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,288,673.00 | 2,892,682.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,910,060.00 | 67,692,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,177,452.00 | 8,573,912.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,090,500.00 | 1,161,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,789,950.00 | 3,633,710.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,284,116.00 | 1,577,652.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 992,650.00 | 55,950.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 78,400.00 | 560,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 941,836.00 | 1,585,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | 21,949,200.00 | 12,084,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 384,900.00 | 1,181,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,911,100.00 | 9,697,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 653,200.00 | 1,206,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,784,715.00 | 8,864,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,800,000.00 | 3,496,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,984,715.00 | 5,368,500.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,696,200.00 | 766,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,696,200.00 | 766,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 773,000.00 | 1,908,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 773,000.00 | 1,458,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,538,686.00 | 14,442,321.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,062,200.00 | 3,283,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,476,486.00 | 11,159,321.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,468,558.00** | **79,589,861.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,636,997.00 | 21,809,280.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 76,080.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,475,600.00 | 7,304,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 5,815,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 8,613,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,161,397.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 439,794.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 439,794.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,391,767.00 | 11,319,678.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,391,767.00 | 11,319,678.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 46,460,903.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 33,960,903.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **56,678,356.00** | **5,484,294.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **56,678,356.00** | **5,484,294.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **56,678,356.00** | **5,484,294.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **56,678,356.00** | 5,484,294.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 56,678,356.00 | 5,484,294.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-56,678,356.00** | **-5,484,294.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **290,170,245.35** | **559,099,097.22** | **-92,491,478.05** | 756,777,864.52 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **290,170,245.35** | **559,099,097.22** | **-92,491,478.05** | 756,777,864.52 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 77,260,926.62 | 77,260,926.62 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **290,170,245.35** | **559,099,097.22** | **-15,230,551.43** | 834,038,791.14 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 609,687,500.00 | 563,706,919.00 | -45,980,581.00 | 92.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 609,687,500.00 | 563,706,919.00 | -45,980,581.00 | 92.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 597,958,300.00 | 556,402,519.00 | -41,555,781.00 | 93.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 387,713,000.00 | 386,720,818.00 | -992,182.00 | 99.7 |
| 210101 | Үндсэн цалин | 299,686,700.00 | 302,263,474.97 | 2,576,774.97 | 100.9 |
| 210102 | Нэмэгдэл | 33,847,600.00 | 38,287,984.81 | 4,440,384.81 | 113.1 |
| 210104 | Урамшуулал | 54,178,700.00 | 46,169,358.22 | -8,009,341.78 | 85.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,293,500.00 | 47,824,552.00 | -4,468,948.00 | 91.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,065,900.00 | 33,362,098.00 | -3,703,802.00 | 90.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,806,900.00 | 3,083,707.00 | -723,193.00 | 81.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,045,500.00 | 2,995,403.00 | -50,097.00 | 98.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 761,400.00 | 769,544.00 | 8,144.00 | 101.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,613,800.00 | 7,613,800.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 81,773,100.00 | 70,584,922.00 | -11,188,178.00 | 86.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,828,000.00 | 2,892,682.00 | -1,935,318.00 | 59.9 |
| 210302 | Түлш, халаалт | 76,245,100.00 | 67,692,240.00 | -8,552,860.00 | 88.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000.00 | 00.00 | -700,000.00 | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,637,800.00 | 10,157,006.00 | -1,480,794.00 | 87.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,183,400.00 | 1,182,600.00 | -800.00 | 99.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,642,000.00 | 3,633,710.00 | -8,290.00 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,758,000.00 | 1,577,652.00 | -180,348.00 | 89.7 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,629,100.00 | 1,618,044.00 | -11,056.00 | 99.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 560,000.00 | 560,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,865,300.00 | 1,585,000.00 | -1,280,300.00 | 55.3 |
| **2105** | **Нормативт зардал** | 28,929,700.00 | 12,084,200.00 | -16,845,500.00 | 41.8 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,237,200.00 | 1,181,200.00 | -56,000.00 | 95.5 |
| 210502 | Хоол, хүнс | 26,486,200.00 | 9,697,000.00 | -16,789,200.00 | 36.6 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,206,300.00 | 1,206,000.00 | -300.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,635,200.00 | 12,448,500.00 | -1,186,700.00 | 91.3 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,150,000.00 | 7,080,000.00 | -70,000.00 | 99.0 |
| 210604 | Урсгал засвар | 6,485,200.00 | 5,368,500.00 | -1,116,700.00 | 82.8 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,547,400.00 | 766,000.00 | -781,400.00 | 49.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,547,400.00 | 766,000.00 | -781,400.00 | 49.5 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,307,500.00 | 1,057,000.00 | -250,500.00 | 80.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 857,500.00 | 607,000.00 | -250,500.00 | 70.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19121100.00 | 14759521.00 | -4,361,579.00 | 77.2 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 3,543,000.00 | -1,457,000.00 | 70.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,121,100.00 | 11,216,521.00 | -2,904,579.00 | 79.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11729200.00 | 7304400.00 | -4,424,800.00 | 62.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,729,200.00 | 7,304,400.00 | -4,424,800.00 | 62.3 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,373,400.00 | 7,304,400.00 | -3,069,000.00 | 70.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,355,800.00 | 00.00 | -1,355,800.00 | 0.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 609,687,500.00 | 563,706,919.00 | -45,980,581.00 | 92.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 523,914,400.00 | 489,953,497.00 | -33,960,903.00 | 93.5 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 523,914,400.00 | 489,953,497.00 | -33,960,903.00 | 93.5 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 84,773,100.00 | 73,453,422.00 | -11,319,678.00 | 86.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 84,773,100.00 | 73,453,422.00 | 11,319,678.00 | 86.6 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 300,000.00 | 700,000.00 | 30.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 300,000.00 | 700,000.00 | 30.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 34.00 | 34.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 20.00 | 1.00 | 95.2 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | 0.00 | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 250.00 | 250.00 | 0.00 | 100.0 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 250.00 | 250.00 | 0.00 | 100.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 250.00 | 250.00 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **34.00** | **34.00** | 0.00 | 100.0 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 21.00 | 20.00 | 1.00 | 95.2 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11.00 | 11.00 | 0.00 | 100.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **27,780,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **27,780,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **0.00** | 13,403,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 13,403,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 13,403,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 14,377,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 14,377,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 5,815,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 8,561,600.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 27,780,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 27,780,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 14,377,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 13,403,300.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Хүрээмарал сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Б.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийг хүлээн авч, оны эцсийн авлагыг бүрэн барагдуулах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашиггүй зарцуулахгүй, цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллан Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 23–ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хүрээмарал сумын ЕБС 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.25-ний өдөр ирүүлсэн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага тайлант онд "Сурагч нэг бүрийг ёс зүйтэй, унших, бичих, ярих чадвараа хөгжүүлсэн, бие даасан, бүтээлч, эрүүл чийрэг иргэн болгон төлөвшүүлэх" зорилго тавьж ажилласан байна.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Хүрээмарал сумын ЕБС нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Хүрээмарал сумын ЕБС нь "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа тул сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд энэ асуудлыг тодруулан шалгахаар шийдвэрлэв.

Тус байгууллагад Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудит хийгдсэн бөгөөд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг зардлын дүн хэт өндөр тул 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар буюу 8266.3 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувиар буюу 13654.2 мянган төгрөгөөр тооцсон тул төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 5387.9 мянган төгрөгөөр их гарсан ба энэ нь 4 дүгээр улиралд зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүрээмарал сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 834038.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7726.09 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

(мян.төг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 33,309.0 | 48,453.0 | 15,144.0 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,789.4 | 9,894.2 | 8,104.9 |
| Бараа материал | 31,519.7 | 38,558.8 | 7,039.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 723,468.8 | 785,585.8 | 62,116.9 |
| Үндсэн хөрөнгө | 1,078,790.7 | 1,194,738.5 | 115,947.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | (355,321.8) | (409,152.7) | (53,830.9) |
| **Нийт хөрөнгө** | 756,777.9 | 834,038.8 | 77,260.9 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 756,777.9 | 834,038.8 | 77,260.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 756,777.9 | 834,038.8 | 77,260.9 |

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд ажиллагсадтай холбоотой 168.9 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны 1620.4 мянга, нийт 1789.3 мянган төгрөгийн авлагатай байснаас 1620.4 мянган төгрөгийн авлагад төлбөрийн акт тогтоож "Өгөөж марал" ХХК-аар төлүүлж, ажиллагсдаас авлагыг суутган бүрэн барагдуулж, ХХОАТ-ын 9.2 мянган төгрөг барагдаагүй үлдэгдлээр байна.

Оны эцэст төсөвт 10000.0 мянган төгрөгөөр тодотгол хийж, 9885.0 мянган төгрөгийн цахим хичээлийн ухаалаг самбар нийлүүлэх гэрээг "Дэвших болор" ХХК-тай гэрээ байгуулж, авлагаар тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38558.8 мянган төгрөг болж өмнөх оноос 7039.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд онд худалдан авсан бараа материалыг зарцуулаагүй бараа материалд үлдэгдлээр байгаатай холбоотой байна. Тайлант онд хандив тусламжаар бараа материал аваагүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 1078790.7 мянган төгрөг байсан ба тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 123386.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс 9864.1 мянган төгрөгийн хөрөнгийг БСШУЯ-ны 2020.12.07-ний өдрийн 12/3151 дүгээр албан албан бичгээр орлогоор бүртгэж, "Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ" төслийн хүрээнд "Нано бриллиант констракшн" ХХК-ийн гүйцэтгэсэн 103530.9 мянган төгрөгийн халуун усны барилга, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр иргэн н.Эрдэнийн гүйцэтгэсэн 9990.7 мянган төгрөгийн эко нойл зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэсэн байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны 11 дүгээр сард Баянхонгор аймаг дахь Төрийн аудитаас явцын шалгалтыг хийхэд дотуур байрны гал тогооны төхөөрөмж, хүүхдийн орыг бэлтгэн нийлүүлээгүй зөрчил илэрч 12500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, үндсэн хөрөнгөөс хасаж, тайлант хугацаанд үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар бүртгэсэн байна.

Тус байгууллага оны эхэнд өглөггүй ба тайлант онд өглөггүй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 77443.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 834220.9 мянган төгрөг болсон байна.

Хүрээмарал сумын ЕБС-ийн улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 44898.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн бөгөөд, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого өмнөх оноос нэмэгдээгүй 2000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Нийт зардал өмнөх онд 552434.3 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 11272.6 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өсөж, 563706.9 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс урсгал шилжүүлгийг 5332.6,мянган төгрөгөөр буруулж, бараа үйлчилгээний зардлыг 16605.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх улсын төсвийн санхүүжилтийг 589849.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 40475.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 630325.4 мянган төгрөгийг баталж, тайлант онд 10, 12 дугаар сард төсөвт өөрчлөлт оруулж, 609687.5 мянган төгрөгөөр баталжээ.

| Анхны батлагдсан төсөв | 2020 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв |
|---|---|
| 589849.7 | 609687.5 |

Тус байгууллагад 34 орон тоо батласнаас гүйцэтгэлээр 33 орон тоогоор ажилласан нь математикийн багшийн орон тоо дутагдалтай байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 523914.4 мянга, орон нутгийн төсвөөс 84773.1 мянган төгрөгийн төсөв баталж, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн санхүүжилтээр 608687.5 бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 300.0 мянган төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 563706.9 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 45280.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 842289.7 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

*Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн ажлын санхүүжилт* */төгрөгөөр/*

| Д/д | Санхүүжилтийн төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Аймгийн БСУГ-аас орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэл болон өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж | 14,377,200 |
| 2 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас тогтоосон төлбөрийн акт | 12,500,000 |
| 3 | Түрээсийн сурах бичгийн үнэ | 903,300 |
| | ДҮН | 27,780,500 |

*Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, дансны хуулга*

Оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 12500.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 133 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

*Хүснэгт 3.Шилэн дансанд байршуулсан мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй | Хугацаа хоцроосон мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 10 | 1 | | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 35 | 1 | | 12 сард хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 80 | 16 | | 5, 8,9 дүгээр сард тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ. |
| | Нийт | 27 | 151 | 133 | 18 | 0 | |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын ЕБС-ийн шилэн данс*

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Б.Бямбаа хийж гүйцэтгэн, аудитаар илэрсэн 200.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, 5698.4 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоосныг шалгагдагч байгууллага хэрэгжүүлж ажилласан боловч, аудитын зөвлөмжийг хариуг 2020.04.01-ний дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр байхад хугацааг хоцроосон ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд төсвийн захирагчтай холбогдож, зөвлөмжийн хариуг 2020.09.22-ний өдрийн 39 дүгээр албан бичгээр гаргуулан авсан байна.

Иймд цаашид аудитын зөвлөмжийн хариуг хугацаанд нь гаргаж, холбогдох нотлох баримтын хамт ирүүлж байх шаардлагатай байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1665.2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан бөгөөд нийт 15333.3 мянган төгрөгийн залруулагдаагүй 6 алдаа зөрчил илэрлээ.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

*Хүснэгт 5. Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал*

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн |
|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 9885.0 |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 569.9 |
| 3 | Албан шаардлага өгсөн | 4 | 3213.2 |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | - | - |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | - | - |
| | Дүн | 7 | 13668.1 |

*Эх сурвалж: Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл Б501*

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 1665.2 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Байгууллагын нягтлан бодогч түрээсийн сурах бичгийн орлогын 541.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дээд шатны төсвийн захирагчаас авсан санхүүжилтээр буруу тайлагнаж, сургуулийн халуун усны орлогоор 300.0 мянган төгрөг оруулсныг нягтлан бодогч үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс хасаж, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор нэмж залруулав.

2. Сар бүрийн цалингийн цэстийг тулган шалгахад тайлант онд 385358.5 мянган төгрөгийн цалин олгосон байхад үр дүнгийн тайланд 386039.5 мянган төгрөгөөр буюу 680.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Ажиллагсдад олгосон цалинг нийгмийн даатгалын мэдээнд ажилтны кодыг буруу мэдээлсэн, 2020 оны 8, 9, 10 дугаар сарын нийгмийн даатгалын мэдээний эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй, 12 дугаар сарын мэдээнд тооцоогүй байхад санхүүгийн тайланд 143.1 мянган төгрөгийн авлага тусгасан байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Шийдвэрлэсэн нь:** НДШ-ийн авлагыг 143.1 мянга, цалингийн зардлыг 680.9 мянган төгрөгөөр бууруулж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 924.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн санхүүгийн тайланд залруулав.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 13668.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 569.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3213.2 мянган төгрөгийн 4 зөрчил албан шаардлага хүргүүлж, 9985.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Нормын хувцас худалдан авах зардлаар 1206.3 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр 1206.0 мянган төгрөг зарцуулж, үйлчлэгч, сантехникч, тогоочид ажлын хувцас авч өгсөн байхад хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 500.0 мянган төгрөгөөр ажиллагсдад ажлын өмд, цамц авч төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажиллагсдаар 500.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын даргын 2020.09.07-ний өдрийн Б/16 дугаар тушаалаар үдийн цайны тогоочоор Ж.Уранбилэгийг томилж, тухайн сард 18 хоног ажилласан байхад бүтэн ажилласнаар 22 хоног тооцсоноос 4 хоногийн цалинд 69.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 69.9 мянган төгрөгийн цалин ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын даргын 2020.12.15-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс байгуулж, хөрөнгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулахдаа тооллогын комисст нярвыг оруулсан байна. Санхүүгийн тайланд үлдэгдлээр байгаа 38558.8 мянган төгрөгийн бараа материалаас 15670.0 мянга, 1194738.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс 60967.8 мянга, нийт 76637.8 мянган төгрөгийн хөрөнгийг тооллогын комисс тоолоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогын дахин хийж, ажиллагсдын эд хөрөнгийн картыг шинэчлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4. Тус байгууллагын нярав, нягтлан бодогч нар хөрөнгийг авсан тухай бүрд орлогод авдаггүй, авсан хугацаанаас хойш төлбөрийг шилжүүлэхдээ нярвын тайланг гаргаж, санхүүгийн программд бүртгэдэг, нярав бараа материалын тайланг гаргахдаа эхний үлдэгдлийг материал тус бүрээр гаргалгүй бөөн дүнгээр гаргадаг, бараа материалын дансанд 1,2 гэх мэт нэртэй материал бүртгэсэн, 57.0 мянган төгрөгийн 1 ширхэг номыг программд 57000 ш 1 төгрөгийн үнэтэйгээр оруулсан, номыг бөөн дүнгээр бүртгэсэн, 2300.0 мянган төгрөгийн өнгөт принтер, ханын төмөр сейф, принтер зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн бол үндсэн хөрөнгийн дансанд 24.0 мянган төгрөгийн хорхойтсон шүдний загвар, 90,0 мянган төгрөгийн шүдний загвар зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй хөрөнгийг бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг шинж чанараар, нэр төрлөөр нь зөв дансанд бүртгэх, номыг нэг бүрийн үнээр салгаж бүртгэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5. Шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгах горим сорил хэрэгжүүлэхэд 2020 оны худалдан авах ажиллагааны тайлангийн гэрээний дүнг 2021 оны гэрээний дүнгээр мэдээлж, 23767.9 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн; байгууллагын даргын 2020.04.06-ний өдрийн А/07 дугаар тушаалаар хөдөө багт ажиллах багш нарын шатахууны зардалд 718.8 мянган төгрөгийн тушаалыг байршуулаагүй; 2020 оны 02 дугаар сард олгосон халаалтын зардлын 9670.3 мянга, 6



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

дугаар сард олгосон өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн 5815.6 мянга, нийт 15485.9 мянган төгрөгийг шилэн дансанд мэдээлээгүй, төсвийн захирагч утасны дугаар өөрчлөгдсөн байхад мэдээллийг өөрчилж оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу мэдээллийг нөхөн байршуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

6. Хүрээмарал сумын ЕБС нь 2020 онд өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийг оруулах төлөвлөгөөтэйгөөс НҮБ-ийн Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны сурагчдын эрүүл, аюулгүй орчин, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор 64 м2 талбай бүхий 4 өрөөтэй халуун ус барьж, тус халуун усны орлогоор 5 дугаар сард 50.0 мянга, 6 дугаар сард 250.0 мянга, нийт 300.0 мянган төгрөгийн орлогыг оруулжээ. Тус халуун усыг ажиллуулахаар орон тоонд батлагдаагүй халуун усны үйлчлэгч, спорт заалны зохион байгуулагчийг 2020.01.02-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар гэрээт ажилтнаар томилж, 2020.12.01-ний өдрийн Б/23 дугаар тушаалаар ээлжийн амралт олгож, төсвөөс тус гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардлыг олгосон байхад өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна. Аудитын явцад өөрийн орлогын талаар сургуулийн захирлаас тодруулахад халуун усны орлогын 135.0 мянган төгрөгөөр бойлуурын засвар хийсэн, сургуулийн спорт заал ашиглуулсны орлогын 607.2 мянган төгрөгөөр сургуулийн гадна талын хамгаалалтын хашаа хийсэн гэсэн тайлбар өгснөөс үзэхэд өөрийн орлогыг тухай бүр төсөвт төвлөрүүлэлгүй, зарцуулсан байгаагаас үзэхэд хэдэн төгрөгийн орлого орсон нь тодорхой бус байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өөрийн орлогыг хууль, журмын дагуу тухай бүр байгууллагын дансанд төвлөрүүлэх, хүүхдийн эрүүл, аюулгүй орчныг хамгаалж, гадны иргэдэд үйлчилдэг байдлыг зогсоох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 9885.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Урсгал засвар хийхдээ бараа материалыг тухай бүр хөрөнгөд бүртгэж тайлан гаргах, өөрийн орлогыг тухай бүр нь төвлөрүүлж байгааг анхаарч, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. **Илрүүлэлт:** Оны эцэст төсөвт 10000.0 мянган төгрөгөөр тодотгол хийж, 9885.0 мянган төгрөгийн цахим хичээлийн ухаалаг самбар нийлүүлэх гэрээг "Дэвших болор" ХХК-тай гэрээ байгуулж, авлагаар тусгасан байна.

1.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг урьдчилсан тооцоо судалгаагүйгээр зарцуулах, хөрөнгийг аваагүй атлаа хөрөнгөд бүртгэх

1.3. **Өгсөн зөвлөмж**: Хөрөнгийг хүлээн авч, оны эцсийн авлагыг бүрэн барагдуулах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашиггүй зарцуулахгүй, цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллан Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР ............................................................Б.ДОЛЖМАА
Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР............................................................А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР............................................................Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.25

6017143544
ВЮА0067 9007423

005 | ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | *Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд* | Аудитын код: |
| 2021.02.23 | | | БНА-2021/134/СТА-ТШЗ |

| | | |
|---|---|---|
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль** | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 500.0 мянган төгрөгөөр ажиллагсдад ажлын өмд, цамц авч төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй. | 500.0 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл |
| 2 | Байгууллагын даргын 2020.09.07-ний өдрийн Б/16 дугаар тушаалаар үдийн цайны тогоочоор Ж.Уранбилэгийг томилж, тухайн сард 18 хоног ажилласан байхад бүтэн ажилласнаар 22 хоног тооцсоноос 4 хоногийн цалинд 69.9 мянган төгрөгийг илүү олгосон. | 69.9 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл |
| 3 | Байгууллагын даргын 2020.12.15-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс байгуулж, хөрөнгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулахдаа тооллогын комисст нярвыг оруулсан ба Санхүүгийн тайланд үлдэгдлээр байгаа 38558.8 мянган төгрөгийн бараа материалаас 15670.0 мянга, 1194738.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс 60967.8 мянга, нийт 76637.8 мянган төгрөгийн хөрөнгийг тооллогын комисс тоолоогүй. | 0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл |
| 4 | Тус байгууллагын нярав, нягтлан бодогч нар хөрөнгийг авсан тухай бүрд орлогод авдаггүй, авсан хугацаанаас хойш төлбөрийг шилжүүлэхдээ нярвын тайланг гаргаж, санхүүгийн программд бүртгэдэг, нярав бараа материалын тайланг гаргахдаа эхний үлдэгдлийг материал тус бүрээр гаргалгүй бөөн дүнгээр гаргадаг, бараа материалын дансанд 1,2 гэх мэт материал бүртгэсэн, 57.0 мянган төгрөгийн 1 ширхэг номыг программд 57000 ш 1 төгрөгийн үнэтэйгээр оруулсан, номыг бөөн дүнгээр бүртгэсэн, 2300.0 мянган төгрөгийн өнгөт принтер, ханын төмөр сейф, принтер зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн бол үндсэн хөрөнгийн дансанд 24.0 мянган төгрөгийн хорхойтсон шүдний загвар, 90,0 мянган төгрөгийн шүдний загвар зэрэг | 2471.0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй хөрөнгийг бүртгэсэн байна. | | | | |
| 5 | Хүрээмарал сумын ЕБС нь 2020 онд өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийг оруулах төлөвлөгөөтэйгөөс НҮБ-ийн Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны сурагчдын эрүүл, аюулгүй орчин, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор 64 м2 талбай бүхий 4 өрөөтэй халуун ус барьж, тус халуун усны орлогоор 5 дугаар сард 50.0 мянга, 6 дугаар сард 250.0 мянга, нийт 300.0 мянган төгрөгийн орлогыг оруулжээ. Тус халуун усыг ажиллуулахаар орон тоонд батлагдаагүй халуун усны үйлчлэгч, спорт заалны зохион байгуулагчийг 2020.01.02-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар гэрээт ажилтнаар томилж, 2020.12.01-ний өдрийн Б/23 дугаар тушаалаар ээлжийн амралт олгож, төсвөөс тус гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардлыг олгосон байхад өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна. Аудитын явцад өөрийн орлогын талаар сургуулийн захирлаас тодруулахад халуун усны орлогын 135.0 мянган төгрөгөөр бойлуурын засвар хийсэн, сургуулийн спорт заал ашиглуулсны орлогын 607.2 мянган төгрөгөөр сургуулийн гадна талын хамгаалалтын хашаа хийсэн гэсэн тайлбар өгснөөс үзэхэд өөрийн орлогыг тухай бүр төсөвт төвлөрүүлэлгүй, зарцуулсан зөрчилтэй байна. | 742.2 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Уганбаяр, Д.Оюунгэрэл |
| 6 | Шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгах горим сорил хэрэгжүүлэхэд 2020 оны худалдан авах ажиллагааны тайлангийн гэрээний дүнг 2021 оны гэрээний дүнгээр мэдээлж, 23767.9 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн; байгууллагын даргын 2020.04.06-ний өдрийн А/07 дугаар тушаалаар хөдөө багт ажиллах багш нарын шатахууны зардалд 718.8 мянган төгрөгийн тушаалыг байршуулаагүй; 2020 оны 02 дугаар сард олгосон халаалтын зардлын 9670.3 мянга, 6 дугаар сард олгосон өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн 5815.6 мянга, нийт 15485.9 мянган төгрөгийг шилэн дансанд мэдээлээгүй, төсвийн захирагч утасны дугаар өөрчлөгдсөн байхад мэдээллийг өөрчилж оруулаагүй байна. | 0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Уганбаяр, Д.Оюунгэрэл |
| 7 | Байгууллагын нягтлан бодогч түрээсийн номны орлогын 541.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дээд шатны төсвийн захирагчаас авсан санхүүжилтээр буруу тайлагнаж, сургуулийн халуун усны орлогоор 300.0 мянган төгрөг оруулсныг нягтлан бодогч үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна. | 841.2 | Санхүүгийн тайланд залруулах | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Уганбаяр, Д.Оюунгэрэл |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Сар бүрийн цалингийн цэстийг тулган шалгахад тайлант онд 385358.5 мянган төгрөгийн цалин олгосон байхад үр дүнгийн тайланд 386039.5 мянган төгрөгөөр буюу 680.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Ажиллагсдад олгосон цалинг нийгмийн даатгалын мэдээнд ажилтны кодыг буруу мэдээлсэн, 2020 оны 8, 9, 10 дугаар сарын нийгмийн даатгалын мэдээний эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй, 12 дугаар сарын мэдээнд тооцоогүй байхад санхүүгийн тайланд 143.1 мянган төгрөгийн авлага тусгасан байна. | | Санхүүгийн тайланд залруулах | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл |
| 9 | Оны эцэст төсөвт 10000.0 мянган төгрөгөөр тодотгол хийж, 9885.0 мянган төгрөгийн цахим хичээлийн ухаалаг самбар нийлүүлэх гэрээг "Дэвших болор" ХХК-тай гэрээ байгуулж, авлагаар тусгасан ба 2021 оны 02 дугаар сард хөрөнгийг хүлээн авсан байна. | 9885.0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл |
| **ДҮН** | | **15333.3** | | | |

---oOo---

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ